



**ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ХЭРЛЭНБАЯН-УЛААН ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 02 өдөр

Дугаар Б/07

Хэрлэнбаян-Улаан

**Н.Мөнхтуяаг үргэлжлүүлэн
ажиллуулах тухай**

Монгол Улсын Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3, 139 дүгээр зүйлийн 139.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Засгийн газрын 2023 оны "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалыг шинэчлэн тогтоох" 240 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт, Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 128 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт, Засгийн газрын 2024 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам", Засгийн газрын 2024 оны "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох тухай" 82 дугаар тогтоолын хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн төвийн эрхлэгч, их эмч Н.Мөнхтуяа нь хүүхэд асрах чөлөөний хугацаанаас өмнө үүрэгт ажилдаа орох хүсэлт гаргасан тул 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн үргэлжлүүлэн ажиллуулсугай.

2. Н.Мөнхтуяагийн ажлыг хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Б.Уранчимэг	Ахлах сувилагч
Гишүүд:	Ц.Оюун-Эрдэнэ	Сувилагч, нярав
	П.Мөнгөнтуяа	Тогооч

3. Эрүүл мэндийн төвийн эрхлэгч, их эмч Н.Мөнхтуяагийн үндсэн цалинг ТҮЭМ-6 зэрэглэлээр тогтоон 1,471,000 (нэг сая дөрвөн зуун далан нэгэн мянга) төгрөгөөр, төрийн албан хаасан хугацааны нэмэгдлийг 2 хувиар, орон нутагт ажилласан нэмэгдлийг 40 хувиар, их эмчийн ажил хавсарсаны нэмэгдэл 40 хувиар тус тус тооцож, олгохыг нягтлан бодогч (Ю.Батбаяр)-д зөвшөөрсүгэй.

4. Албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Н.Мөнхтуяад үүрэг болгосугай.

ЗАХИРАГЧ  Ж.МАРТ

